



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 384

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй, засвар хийхэд эдийн засгийн хувьд үр ашиггүй 7 нэрийн нийт 23,366,969.30 (хорин гурван сая гурван зуун жаран зургаан мянга есөн зуун жаран есөн төгрөг гучин мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин, Улаанбаатар хотын Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга А.Золзаяа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001295

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2021 оны...⁰⁹... дугаар сарын ...⁰⁸... өдрийн
...³⁸⁴... дугаар тогтоолын хавсралт

Улаанбаатар хотын Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	ABK-1 тоног төхөөрөмж	2010-12-29	1	ш	20,000,000.00	20,000,000.00
2	Цаг уурын автомат станцын хөрсний гүний мэдрүүр	2014-10-16	1	ш	136,461.50	1,091,692.00
3	Эргэдэг сандал	2010	1	ш	12,000.00	12,000.00
4	Эргэдэг сандал	2010	1	ш	27,500.00	27,500.00
5	Принтер	2003	1	ш	232,777.30	232,777.30
6	Компьютер дел 2101	2008	1	ш	1,103,000.00	1,103,000.00
7	Компьютер /Dell opt 380/	2/28/2011	1	ш	900,000.00	900,000.00
Нийт дүн			7			23,366,969.30 (хорин гурван сая гурван зуун жаран зургаан мянга есөн зуун жаран есөн төгрөг гучин мөнгө)